



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/62/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273465 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.2 Төлбөрийн акт.....	17
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/134
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА А.МӨНХТУУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь төрийн захиргааны байгууллагыг мэргэшсэн чадварлаг хариуцлага бүхий албан хаагчдаар бэхжүүлэн өндөр бүтээмжтэй ажиллан төрийн үйлчилгээг чанартай шүүрхай хүргэх гэсэн эрхэм зорилгын дор чанарын удирдлагын тогтолцоо ISO стандарт нэвтрүүлэн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар цалингийн зардал, бичиг хэрэг, шуудан холбоо, дотоод албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардлууд нь хэмнэгдэж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 42,230.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	106,710,903.36	92,409,389.71
33	АВЛАГА	1,725,001.36	760,723.36
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	40,355.36	44,355.36
33500	Бусад авлага	1,684,646.00	716,368.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,684,646.00	716,368.00
35	БАРАА МАТЕРИАЛ	104,985,902.00	91,648,666.35
35400	Хангамжийн материал	104,985,902.00	86,648,666.35
35410	Бичиг хэргийн материал	40,900.00	961,150.00
35420	Аж ахуйн материал	81,770,211.00	49,443,820.00
35470	Бусад хангамжийн материал	23,174,791.00	36,243,696.35
35600	Мал амьтад	0	5,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,383,194,211.99	1,542,751,768.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,383,194,211.99	1,542,751,768.55
39200	Биет хөрөнгө	1,249,639,878.75	1,409,469,101.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	807,880,657.00	807,880,657.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-409,572,954.46	-452,841,228.23
39203	Авто-тээврийн хэрэгсэл	225,770,667.20	282,079,757.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-146,627,334.26	-172,265,667.74
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	280,310,559.50	329,193,238.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-190,307,964.92	-207,710,162.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,085,587.00	28,824,781.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,639,472.63	-20,638,233.27
39209	Зам, гүүрийн байгууламж	409,123,410.00	424,123,410.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-286,139,835.20	-320,296,921.84
39214	Бусад үндсэн хөрөнгө	744,580,036.55	974,337,459.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-200,823,477.03	-263,217,986.33
39300	Биет бус хөрөнгө	133,554,333.24	133,282,666.56
39301	Програм хангамж	2,040,000.00	2,040,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,371,666.76	-1,643,333.44
39303	Бусад биет бус хөрөнгө	132,886,000.00	132,886,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,489,905,115.35	1,635,161,158.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,055,146.00	203,368.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,055,146.00	203,368.00
41300	Өглөг	1,055,146.00	203,368.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	4,000.00
41360	Бусад өглөг	1,055,146.00	199,368.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,039,146.00	183,368.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	16,000.00	16,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,488,849,969.35	1,634,957,790.26
51	Засгийн газрын хувь оролцоо	1,488,849,969.35	1,634,957,790.26
51100	Засгийн газрын оруулсан капитал	916,474,832.44	916,474,832.44
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	916,474,832.44	916,474,832.44
51200	Хуримтлагдсан үр дүн	382,135,404.85	528,256,485.76
51210	Өмнөх үеийн үр дүн	478,055,791.07	382,036,164.85
51220	Тайлант үеийн үр дүн	-95,920,386.22	146,220,320.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190,239,732.06	190,226,472.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,489,905,115.35	1,635,161,158.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	707,982,693.04	1,182,083,768.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,282,635.00	354,166,151.00
120	Нийтлэг татварын бус орлого	195,282,635.00	354,166,151.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	174,094,973.00	351,591,151.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,187,662.00	2,575,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	512,700,058.04	827,917,617.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	96,370,158.04	178,609,717.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	14,859,500.00	0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	0	7,508,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	64,506,469.00	20,034,779.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	17,004,189.04	151,066,938.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	416,329,900.00	649,307,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	416,329,900.00	649,307,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	803,919,174.26	972,447,124.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	803,919,174.26	957,110,224.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	781,139,364.62	779,745,768.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,384,726.12	200,594,497.62
210101	Үндсэн цалин	173,333,617.59	169,502,243.26
210102	Нэмэгдэл	43,865,245.54	31,092,254.36
210105	Гэрээт ажлын хөлс	42,185,862.99	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,454,799.44	25,594,278.90
210201	Тэтгэврийн даатгал	23,254,572.96	17,436,386.86
210202	Тэтгэмжийн даатгал	2,580,878.41	2,051,339.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,064,702.90	1,630,991.78
210204	Ажилгүйдлийн даатгал	493,591.86	398,081.26
210205	Эрүүл мэндийн даатгал	5,061,053.31	4,077,479.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,021,159.00	44,061,816.08
210301	Гэрэл, цахилгаан	11,763,847.00	10,554,504.08
210302	Түлш, халаалт	32,817,312.00	32,817,312.00
210303	Цэвэр, бохир ус	1,440,000.00	690,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,441,505.80	96,497,425.65
210401	Бичиг хэрэг	2,737,130.00	6,492,050.00
210402	Тээвэр, шатахуун	12,782,745.80	31,384,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,893,780.00	2,612,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,027,850.00	12,972,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	3,985,780.00
210408	Бараа материал акталсны зардал	0	39,050,595.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,982,200.00	38,381,500.00
210604	Урсгал засвар	2,982,200.00	38,381,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,748,000.00	7,249,600.00
210702	Дотоод албан томилолт	1,748,000.00	7,249,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,354,805.63	50,268,538.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,209,505.63	48,664,070.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	340,000.00	640,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	311,100.00	246,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,200.00	291,011.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	0	404,507.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	411,752,168.63	317,098,111.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,164,911.90	100,904,817.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	268,483,256.73	216,193,294.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,779,809.64	177,364,456.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,409,900.00	15,914,271.10
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,409,900.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	15,914,271.10
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	16,369,909.64	161,450,185.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,369,909.64	161,450,185.75
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	15,336,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	15,336,900.00
221001	Их засвар	0	15,336,900.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-95,936,481.22	209,636,643.91
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	16,095.00	0
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	16,095.00	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	63,416,323.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0	3,240,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0	59,157,323.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	1,019,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-95,920,386.22	146,220,320.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	519,579,557.55	827,917,617.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,683.51	0
120	Нийтлэг татварын бус орлого	78,683.51	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	78,683.51	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,683.51	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	519,500,874.04	827,917,617.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,170,974.04	178,609,717.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	14,859,500.00	0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	7,508,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,506,469.00	20,034,779.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,805,005.04	151,066,938.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	416,329,900.00	649,307,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	416,329,900.00	649,307,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	519,139,557.55	720,004,694.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	519,139,557.55	720,004,694.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	496,359,747.91	542,640,237.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,496,973.14	200,594,497.62
210101	Үндсэн цалин	173,445,864.61	169,502,243.26
210102	Нэмэгдэл	43,865,245.54	31,092,254.36
210105	Гэрээт ажлын хөлс	42,185,862.99	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,454,799.44	25,594,278.90
210201	Тэтгэврийн даатгал	23,254,572.96	17,436,386.86
210202	Тэтгэмжийн даатгал	2,580,878.41	2,051,339.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,064,702.90	1,630,991.78
210204	Ажилгүйдлийн даатгал	493,591.86	398,081.26
210205	Эрүүл мэндийн даатгал	5,061,053.31	4,077,479.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,021,159.00	44,061,816.08
210301	Гэрэл, цахилгаан	11,763,847.00	10,554,504.08
210302	Түлш, халаалт	32,817,312.00	32,817,312.00
210303	Цэвэр, бохир ус	1,440,000.00	690,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,025,225.80	61,188,980.00
210401	Бичиг хэрэг	2,352,500.00	7,412,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,782,745.80	31,384,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,893,780.00	2,612,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,996,200.00	15,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	4,280,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,981,200.00	39,281,500.00
210604	Урсгал засвар	2,981,200.00	39,281,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,748,000.00	7,249,600.00
210702	Дотоод албан томилолт	1,748,000.00	7,249,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,354,805.63	50,268,538.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,209,505.63	48,664,070.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	340,000.00	640,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	311,100.00	246,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,200.00	291,011.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	0	404,507.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,277,584.90	114,401,027.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,173,584.90	114,401,027.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,779,809.64	177,364,456.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,409,900.00	15,914,271.10
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,409,900.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	15,914,271.10
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	16,369,909.64	161,450,185.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,369,909.64	161,450,185.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	440,000.00	107,912,923.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	440,000.00	107,912,923.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	440,000.00	107,912,923.00
2200	Дотоод эх үүсвэрээр	440,000.00	107,912,923.00
221001	Их засвар	0	7,250,000.00
223001	Бусад хөрөнгө	0	9,105,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	440,000.00	91,557,023.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-440,000.00	-107,912,923.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.44	190,239,732.06	478,656,791.07	1,585,371,355.57
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-601,000.00	-601,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	916,474,832.44	190,239,732.06	478,055,791.07	1,584,770,355.57
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-95,920,386.22	-95,920,386.22
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.44	190,239,732.06	382,135,404.85	1,488,849,969.35
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	916,474,832.44	190,239,732.06	382,135,404.85	1,488,849,969.35
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-99,240.00	-99,240.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	916,474,832.44	190,239,732.06	382,036,164.85	1,488,750,729.35
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-13,260.00	0	-13,260.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	146,220,320.91	146,220,320.91
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	916,474,832.44	190,226,472.06	528,256,485.76	1,634,957,790.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	649,307,900.00	607,077,455.05	42,230,444.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	543,068,300.00	503,324,232.05	39,744,067.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,168,300.00	492,529,160.95	38,639,139.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,616,900.00	200,594,497.62	17,022,402.38
210101	Үндсэн цалин	173,682,100.00	169,502,243.26	4,179,856.74
210102	Нэмэгдэл	43,934,800.00	31,092,254.36	12,842,545.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	29,378,200.00	25,594,278.90	3,783,921.10
210201	Тэтгэврийн даатгал	20,673,600.00	17,436,386.86	3,237,213.14
210202	Тэтгэмжийн даатгал	2,176,100.00	2,051,339.64	124,760.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,740,900.00	1,630,991.78	109,908.22
210204	Ажилгүйдлийн даатгал	435,200.00	398,081.26	37,118.74
210205	Эрүүл мэндийн даатгал	4,352,400.00	4,077,479.36	274,920.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,489,300.00	44,061,816.08	4,427,483.92
210301	Гэрэл, цахилгаан	14,004,000.00	10,554,504.08	3,449,495.92
210302	Түлш, халаалт	33,045,300.00	32,817,312.00	227,988.00
210303	Цэвэр, бохир ус	1,440,000.00	690,000.00	750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,902,300.00	58,800,180.00	1,102,120.00
210401	Бичиг хэрэг	8,325,500.00	7,412,300.00	913,200.00
210402	Тээвэр, шатахуун	28,995,300.00	28,995,300.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,800,000.00	2,612,000.00	188,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	15,500,000.00	15,500,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,281,500.00	4,280,580.00	920.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,281,500.00	39,281,500.00	0.00
210604	Урсгал засвар	39,281,500.00	39,281,500.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	7,257,300.00	7,249,600.00	7,700.00
210702	Дотоод албан томилолт	7,257,300.00	7,249,600.00	7,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	51,652,800.00	50,268,538.35	1,384,261.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	48,707,500.00	48,664,070.35	43,429.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	640,000.00	640,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	311,100.00	246,950.00	64,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,200.00	291,011.00	38,189.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	22,000.00	143,000.00
210807	Газрын төлбөр	1,500,000.00	404,507.00	1,095,493.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,590,000.00	66,678,750.00	10,911,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,590,000.00	66,678,750.00	10,911,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,900,000.00	10,795,071.10	1,104,928.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,900,000.00	10,795,071.10	1,104,928.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,900,000.00	10,795,071.10	1,104,928.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	106,239,600.00	103,753,223.00	2,486,377.00
221001	Их засвар	25,571,000.00	25,571,000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	80,668,600.00	78,182,223.00	2,486,377.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	649,307,900.00	607,077,455.05	42,230,444.95
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	649,307,900.00	607,077,455.05	42,230,444.95
320001	Орон нутгийн төсвөөс	649,307,900.00	607,077,455.05	42,230,444.95

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103,170,974.04	59,389,977.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,170,974.04	59,389,977.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,895,036.33	54,270,777.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,187,445.80	2,388,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,187,445.80	2,388,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,481,200.00	
210604	Урсгал засвар	1,481,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,209,505.63	51,881,977.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,209,505.63	51,881,977.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,016,884.90	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,912,884.90	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,275,937.71	5,119,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		5,119,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		5,119,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,275,937.71	
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	12,275,937.71	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	103,170,974.04	59,389,977.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,170,974.04	59,389,977.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,859,500.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан		7,508,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	64,506,469.00	20,034,779.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,805,005.04	31,847,198.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь төрийн захиргааны байгууллагыг мэргэшсэн чадварлаг хариуцлага бүхий албан хаагчдаар бэхжүүлэн өндөр бүтээмжтэй ажиллан төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх гэсэн эрхэм зорилгын дор чанарын удирдлагын тогтолцоо ISO стандарт нэвтрүүлэн ажилласан байна.

ISO стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд төрийн албан хаагч нарт сургалт зохион байгуулан, өрөөний дотоод тохижилт, зохион байгуулалтыг сайжруулж засвар үйлчилгээ хийж, төрийн албан хаагчид өөрсдийн сейф, баримт бичиг хавтсыг эрэмбэлэн 5S зарчмыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 24 арга хэмжээтэй байгуулан ажиллаж, гүйцэтгэл хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлөөр 94,4% тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын баг нь 2022 оны 3 дугаар сарын 29-нд хуралдаж 2022 оны төлөвлөгөөг батлах, багаар хамтарч ажиллах талаар хэлэлцэж, өмнөх оны хяналт шалгалтын ажлаа дүгнэж хэлэлцсэн байна.

Тамгын газрын дотоод хяналтын багийн 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 10 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулсан байна.

Тайлант хугацаанд батлагдсан төлөвлөгөөний дагуу шилэн дансны хэрэгжилтэд 2 удаа, өр, авлагын барагдуулалт, албан томилолт, шатахууны зарцуулалт, өвс тэжээлийн бүрдүүлэлт, зарцуулалтад болон орон нутгийн өмчийн тооллогод дотоод хяналтыг гүйцэтгэн, тайлан бичиж хяналтаар илэрсэн зөрчлийг арилгасан мэдээллийг авч ажилласан байна

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь сумын Засаг даргын тамгын газрын даргын 2011 оны 02 дугаар сарын 13-ны №09 дугаар тушаалаар батлагдсан байна.

Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 145,256.0 мянган төгрөгөөр буюу 9,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	1,725.0	760.7	-964.3
Бараа материал	104,985.9	91,648.7	-13,337.2
Үндсэн хөрөнгө	1,383,194.2	1,542,751.7	159,557.5
Нийт хөрөнгө	1,489,905.1	1,635,161.1	145,256.0
Өр төлбөр	1,055.1	203.3	-851.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,488,849.9	1,634,957.8	146,107.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,489,905.1	1,635,161.1	145,256.0

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын дансны үлдэгдэл 91,648.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,337.2 мянган төгрөгөөр буурсан нь 39,079.6 мянган төгрөгийн материал акталснаас нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,542,751.7 мянган төгрөг болж, 159,557.5 төгрөгөөр өссөн нь 346,591.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй бүртгэж, 26,062.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 62,397.3 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Эздийн өмч 1,634,957.8 мянган төгрөг болж, 146,107.9 мянган төгрөгөөр өссөн нь тайланд оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засаг даргын тамгын газар нь 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 495,206.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас тамгын газрын урсгал үйл ажиллагааны зардлаас 93,084.1 мянган төгрөгөөр бууруулж, сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 04 тоот тогтоолоор тамгын газрын урсгал зардлыг 402,122.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь батлагдсан төсвийн төслөөс цалин, шимтгэлийн зардлыг 28,689.5 мянган төгрөгөөр, урсгал засварыг 26,954.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх бараа ажил үйлчилгээний зардлыг 45,356.5 мянган төгрөгөөр хассанаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 112,968.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 515,090.7 мянган төгрөгөөр тодотгосон ба хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардалд 134,217.2 мянган төгрөгийг нэмж, нийт 649,307.9 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 02 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 649,307.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 649,307.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 607,077.5 мянган төгрөг буюу 93,5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг батлагдсан орон дутуу зарим албан тушаалыг хавсран гүйцэтгүүлснээс шалтгаалан цалин, шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардалд батлагдсан зарим арга хэмжээг хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70106/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	396,031.8	362,054.8	33,977.0	98%
2	70106/ 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	47,104.0	42,485.1	4,618.9	89%
3	70106/80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	48,707.5	48,664.0	43.5	99%
4	70106/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	11,900.0	10,795.0	1,105.0	90%
5	70106/80918 Бусад	106,239.6	103,753.2	2,486.3	97%
6	70106/ 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.0	15,000.0	0	100%
7	70106/82801 Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100%
8	71411/81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	3,825.0	3,825.0	0	100%
9	71411/82212 Хур хог хаягдал, орчныг бохирдол	15,500.0	15,500.0	0	100%
		649,307.9	607,077.1		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд цахим тендерийн хураамж 189.0 мянган төгрөг, Малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх шатахуунд 388.8 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/729 дугаар захирамжаар зудын хүндрэл 3,000.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 137,485.3 мянган төгрөг, ажлын байрны түрээс 799.0 мянган төгрөг, улс төрийн албан хаагчдын тэтгэмж 5,119.2 мянган төгрөг, 2021 оны үйл ажиллагааны үр дүн 2,000.0 мянган төгрөг, Засгийн газраас олгох усны дэмжлэг 14,499.3 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэ 1185.4 мянган төгрөг, статистик хэлтсээс 6,291.3 мянган төгрөг, Ажил зуучлалын зардалд 126.0 мянган төгрөг, өмнөх оны буцаан төвлөрүүлэлт 7,301.5 мянган төгрөг, нийт 178,609.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

Нэмэлтийн харилцах данснаас газрын дуудлага худалдааны орлого 12,290.0 мянган төгрөгийг буцаасан, худаг засварт 9,904.9 мянган төгрөг, ХАА-н тооллого, судалгаанд 6,291.3 мянган төгрөг, өмгөөллийн хөлс 13,050.0 мянган төгрөг, газрын даамал компьютер принтер дэлгэц авахад 4,159.7 мянган төгрөг, программын төлбөрт 288.7 мянган төгрөг, Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн тэтгэмж 5,119.2 мянган төгрөг, зуд шатахуун материалд 3,000.0 мянган төгрөг, ажил зуучлалын 126.0 мянган төгрөг, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 2,771.3 мянган төгрөг, үйл ажиллагааны үр дүн, шатахуунд 2,388.8 мянган төгрөг, нийт 59,389.9 мянган төгрөгийг зарцуулж, 119,219.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106/ орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Тайлант онд	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	97,6%	602,005.3	587,752.1
2	71411/Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	Тайлант онд	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	100%	19,325.0	19,325.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлага 515,090.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 7,726.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,794.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, ажилласнаар цалингийн зардал бүтэц орон тоо дутуугаас 17,022.4 мянган төгрөг, бичиг хэрэг, шуудан холбоо, дотоод албан томилолт, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1,109.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 10,911.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлаас 1,104.9 мянган төгрөг, бусад хөрөнгийн зардлаас 2,486.3 мянган төгрөгийн зардлууд нь хэмнэгдсэн ба тогтмол зардлаас 4,427.4 мянган төгрөг хэрэглээнээс хэмнэгдэж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 42,230.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянчандмань сумын ЗДТГ нь шилэн дансанд байршуулбал зохих мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 107,643.7 мянган төгрөгийн 4 орлогын, 11,798.2 мянган төгрөгийн 2 зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага бичигдсэнийг хэрэгжүүлэн, биелэлтийг ЗДТГ-ын 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр 03/227 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	65,198.5	2	65,198.5	100
Зөвлөмж					
Нийт дүн	2	65,198.5	2	65,198.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар хөрөнгийн тооллого тооцоо бодолтод анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 459,700.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 459,700.3 мянган төгрөгийн алдааг залруулав.

Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад дараах алдаа илэрлээ. Үүнд:

1. Санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнгээс 128,124.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

2. Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаас 29,112.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

3. Цалин, нэмэгдэл урамшууллын зардлыг санхүү үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд 4,595.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

4. Нэмэлт дансны оны эцсийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлсэн 7,585.7 мянган төгрөгийг авлагаар тайлагнасан.

5. Үндсэн хөрөнгийн бусад үндсэн хөрөнгө дансанд 290,282.1 мянган төгрөгийн өвс хаман боогч, үрлүүр болон бие чийрэгжүүлэлтийн танхимын дасгалын тоног төхөөрөмжүүдийг буруу ангилан бүртгэсэн байна.

Дээрх 459,700.3 мянган төгрөгийн алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

5.2 Төлбөрийн акт

Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 6,169.2 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д "Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлан тооцоо бодолттой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө дансанд зам гүүрний барилга байгууламж дансанд зам засварын орлогыг 15,000.0 мянган төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө дансанд зам сайжруулалтыг 15,000.0 мянган төгрөгөөр гэх мэтээр ижил төрлийн хөрөнгийг өөр өөр дансанд бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2006 оны "Журам батлах тухай" 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 4.11-д "Үндсэн хөрөнгийг дараах байдлаар ангилна" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "үнэлгээ ба хуваарилалт", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Хөрөнгө бараа материалыг данс бүртгэлд тусгахдаа нягтлан бодох бүртгэлийн стандарт, заавар, журмын дагуу анхан шатны баримтад тулгуурлан үнэн зөв ангилан бүртгэж тайлагнаж хэвших

2. Тайлан тооцоо бодолттой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 107,643.7 мянган төгрөгийн 4 орлогын, 11,798.2 мянган төгрөгийн 2 зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээлли йг тусгахгүй орхигдуул сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөм ж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СҮДТ-д үнэ төлбөргүй орлогын дүн зөрүүтэй	1	128,124.5			1	128,124.5	1	128,124.5				
МГТайланд хөрөнгийн зардал зөрүүтэй	1	29,112.8			1	29,112.8	1	29,112.8				
Цалин шимтгэлийг зөрүүтэй	1	4,595.2			1	4,595.2	1	4,595.2				
Авлага буруу илэрхийлсэн	1	7,585.7			1	7,585.7	1	7,585.7				
Хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн	1	290,282.1			1	290,282.1	1	290,282.1				
Дүн	5	459,700.3			5	459,700.3	5	459,700.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлого дутуу төвлөрүүлсэн	1	6,169.2	1	6,169.2								
Үндсэн хөрөнгө буруу ангилан бүртгэсэн	1	30,000.0					1	30,000.0				
Дүн	2	36,169.2	1	6,169.2			1	30,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	1	119,441.9					1	119,411.9
Дүн	1	119,441.9					1	119,411.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	119,441.9					1	119,411.9

